



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 486

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2016, 2017 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 163.5 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2016, 2017 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захираг Ц.Амарсанаад дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаанд даацтуулж мөрдэж ажиллах;

2.2.Худалдан авах ажиллагааны зөрчил, дутагдал гаргасан үнэлгээний хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

2.3.Төндөрийн бичиг баримтад заагаагүй нөхцөлд урьдчилгаа төлбөр олгохгүй байх;

2.4.Төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгийг зохистой удирдах, авлага, өглөгддүүлэхийг бууруулах, хугацаа хэтэрсэн авлагыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх;

2.5.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах болон энэхүү тогтоолоор өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах, биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б. ГАВАА

0002393

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2018 оны 10 дугаар сарын 30-дэдрийн
186 дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал түүнийг
арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын дүн	Хариуцах эзэн	Дүн сая төгрөг	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Тендерийн бичиг баримтад заагаагүй нөхцөлд урьдчилгаа төлбөр олгосон	Захирал – Ц.Амарсанаа Ерөнхий ня.бо – Г.Гантуул Үнэлгээний хорооны дарга, гишүүд	163.5	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах
	Дүн		163.5	